



ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/10

Бор-Өндөр

Бусад хөрөнгийн зардлаас хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг Төсвийн тухай хуулийн 16.4.15, 16.5.5 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бор-Өндөр сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу Бор-Өндөр дахь Онцгой байдлын хэлтэст "Туулах чадвар бүхий шуурхай албаны авто машин" нийлүүлэх ажилд "МТМЧ" ХХК шалгарч ажлыг гэрээний дагуу 100 хувь гүйцэтгэсэн тул 50 хувийн үлдэгдэл санхүүжилт болох 29,750,000 (хорин есөн сая долоон зуун тавин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Авто машины үлдэгдэл санхүүжилт болох 29,750,000 (хорин есөн сая долоон зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын бусад хөрөнгийн зардлаас зохих хууль дүрэм, журмын дагуу хяналт тавьж зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (О.Мөнхцэцэг)-д даалгасугай.

ДАРГА



З.УУТАНЖАРГАЛ